

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ НЭГТГЭСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН”-д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:
ДУА-2021/01/СТА-ТЕЗ

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Х.Наранцацрал

Утас: 70592439

Аудитор Б.Гантуяа

Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Утас: 7059-3113

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Наранцацрал Аудитор: Б.Гантуяа Т.Оюун-Эрдэнэ Л.Уранбилэг Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7059-3113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот 2021 оны 4 дүгээр сар	Товчилсон үгс Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО <i>1.1 Орлогыг судалгаа, шинжилгээ хийлгүй, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан бодитой бус төлөвлөж байна.</i> <i>1.2 Орон нутгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.</i> 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА <i>2.1 Орон нутгийн төсвийн зарлагыг өмнөх оноос 10,375.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.</i> <i>2.2 Төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил өмнөх оноос 19.0 хувиар буурсан ч төсвийн хөрөнгийг үрэлгэн, хууль, тогтоомж зөрчин зарцуулсан зөрчлүүд илэрсээр байна.</i> <i>2.3 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.</i> Дүгнэлт Зөвлөмж Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар Тайлан баталгаажуулах тушаал	
--	---	--



ТОВЧИЛСОН ҮГС

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ТЗШБ	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
АНАТ	Ангийн нөөц ашигласны төлбөр
ДХСШ	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай зарцуулсан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон ТЕЗ-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн зохицуулалт хийсэн судалгаа, мэдээлэл болон татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль;
- Татварын багц хуулиуд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Төрийн аудитын стандарт /MNS 6817-4:2020/-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Наранцацрал хянан удирдаж, ахлах аудитор Т.Батсайхан чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Гантуяа, Т.Оюун-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 16-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

1.1 Орлогыг судалгаа, шинжилгээ хийлгүй, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан бодитой бус төлөвлөж байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийг баталжээ.

Тус хуулийн 15 дугаар зүйлд Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 11,671.5 сая төгрөгөөр, 17 дугаар зүйлд ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 5,176.6 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 28,623.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Өмнөх онтой харьцуулахад санхүүгийн дэмжлэг 2,327.0 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,549.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 5,651.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Дундговь аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх¹ хэсэгт заасны дагуу аймгийн ИТХ-д төсвийн төслийг өргөн мэдүүлж, төсвийн орлого, зарлагыг батлуулжээ.

Дундговь аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор 2020 оны орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 52,775.4 сая төгрөгөөр баталсныг 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 3 дугаар тогтоолоор 51,886.2 сая төгрөг болгон 889.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Энэ нь улсын хэмжээнд цар тахлын дэгдэлтийн нөлөөгөөр эдийн засгийн хүндрэл үүссэнээс шалтгаалан 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулж баталсантай холбоотойгоор улсын төсвөөс олгох санхүүжилтийг 1,248.9 сая төгрөгөөр бууруулан, орон нутгийн

¹ Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 /Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ/



орлогын төлөвлөгөөг 359.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал:

- Аймгийн татварын болон татварын бус орлогыг 90.6 сая төгрөгөөр, ОНХО-ын эхний үлдэгдлийг 269.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- Улсын төсвөөс аймгийн төсөвт авах санхүүгийн дэмжлэгийг 360.2 сая төгрөгөөр, улсын төсвөөс аймгийн төсөвт авах орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 611.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг 277.7 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.

Тус тогтоолоор аймгийн төсвийн эх үүсвэрийг дараах ангиллын дагуу баталжээ:



Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоол

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 10 дугаар тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 4,474.8 сая төгрөгөөр баталснаас 4,054.0 сая төгрөг нь татварын, 420.8 сая төгрөг нь татварын бус орлого байна.


2020 онд 5 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 37.7-240.1 сая төгрөгөөр нэмж баталсан ч гүйцэтгэлээр 11.4-413.8 сая төгрөг буюу 3.4-23.1 хувиар давж биелсэн байгаа нь орлого оруулах нөөц боломжийг дутуу тооцож төлөвлөснийг харуулж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2 /сая төгрөг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ		Төлөвлөгөө			гүйцэтгэл /2020 он/	Зөрүү	
		2019 он	2020 он	зөрүү		дүнгээр	хувь
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	3,304.9	3,545.0	240.1	3,958.8	413.8	111.7
2	Дуудлага худалдаа сонгон	70.3	200.0	129.7	246.2	46.2	123.1

	шалгаруулалтын орлого						
3	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	97.0	134.7	37.7	146.1	11.4	108.5
4	Хадгаламжийн хүүгийн орлого	514.3	751.9	237.6	777.3	25.4	103.4

Дээрх орлогуудын өмнөх таван жилийн төлөвлөлтийг харьцуулж үзвэл:




Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого тогтмол өсөлттэй байсан ч 2018 онд огцом өсгөж төлөвлөсөн нь төрийн албан хаагчдын цалинг нэмэгдэхээр тооцсон боловч нэмэгдээгүй, мөн төлөвлөгөө батлахдаа нийгмийн

даатгалын шимтгэл төлөлтийн хувийг нэмэгдүүлснийг тооцоогүй байсныг 2019 онд буцаан бууруулж баталсантай холбоотой.




Дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлогын төлөвлөгөөг 2020 онд өмнөх онуудаас 2.4 дахин нэмж төлөвлөсөн ч давж биелсэн байна. Энэ нь аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн саналыг үндэслэн бодитой төлөвлөсөнтэй

холбоотой байна.



Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө жил бүр тасардаг ч төлөвлөгөө гүйцэтгэл аль аль нь тогтмол өсөлттэй байгаа нь 2018 оноос эхлэн сумд ИТХ-аараа хураамжийн хэмжээг тогтоож, зарим айл өрхийн гэрэл цахилгааны хэрэглээний төлбөртэй хамт хураах ажлыг

зохион байгуулсантай холбоотой байна. /орлогын төлөвлөгөө 2019 онд 12 сум тасалсан бол 2020 онд 5 сум тасалсан байна./



Хадгаламжийн хүүгийн орлогын төлөвлөлт тогтмол өсөлттэй, төлөвлөгөө бүрэн биелдэг байна. Энэ нь хадгаламжийн хүүгийн хувь тогтвортой байгаа ч иргэдийн мөнгөн хадгаламжийн хэмжээний өсөлтөөс шалтгаалжээ.


Сүүлийн 3 жилээр орлогын төлөвлөгөөг харьцуулахад өсөлт, бууралт ихтэй дараах орлогууд байна. Үүнд:



Хүснэгт №3 /сая төгрөг/

	Нэр төрөл	2018 он	2019 он	2020 он
1	Улсын тэмдэгтийн хураамж	45.9	81.5	145.0
2	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	28.0	49.4	19.2
3	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	150.0	150.0	30.4
4	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	85.0	70.3	200.0

Үүнийг графикаар харуулбал:



Графикаас харахад орлогыг төлөвлөхдөө нэр төрөл тус бүрээр 3-5 жилээр харьцуулан судалж үзэх, тухайн тайлант оны онцлог, аймгийн Татварын хэлтсийн орлого бүрдүүлэх боломж, цаг үе, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх онд орсон нэг удаагийн шинж чанартай орлого

зэргийг тооцон орлогыг бодитой төлөвлөх шаардлагатай байна.

Төлөвлөгөөг олон жилийн харьцуулсан судалгаа, шинжилгээнд үндэслээгүйгээс орлогын төлөвлөгөө тасрах, шаардлагагүй үед төсвийн тодотгол хийх эсвэл өөрчлөн батлах зэрэг хүндрэл үүсэх үр дагавартайг анхаарах нь зүйтэй.

1.2 Орон нутгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль болон аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын дагуу орон нутгийн төсвийн орлогыг дараах байдлаар баталж, бүрдүүлсэн байна.

Хүснэгт №4 /сая төгрөг/

Орлогын эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Аймаг			
ТЗШ	28,623.3	26,774.4	(1,848.9)
Санхүүгийн дэмжлэг	11,671.5	11,671.5	-
ОНХС	5,176.6	4,972.6	(204.0)
Эрүүл мэндийн даатгал	305.7	222.4	(83.3)
Татварын орлого	4,474.8	5,958.0	1,483.2
Урьд оны үлдэгдэл	1,115.7	1,182.5	66.8
ОНЕО үлдэгдлээс	428.8	502.2	73.4
Төвлөрүүлэх орлого	89.8	226.0	136.2



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дүн	51,886.2	51,509.6	376.6
Сум			
Татварын орлого	1,689.1	1,584.0	(105.1)
Урьд оны үлдэгдэл	2,312.1	2,472.8	160.7
ОНЕО үлдэгдлээс	473.1	479.7	(6.6)
Төвлөрүүлэх орлого	1,767.3	1,714.1	53.2
Дүн	6,241.6	6,250.6	(9.0)
Нийт дүн	58,127.8	57,760.2	367.6

Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 100 хувь, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн 96.1 хувийг авчээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг бүрэн авч гүйцэтгэлээр 26,774.4 сая төгрөгийг зарцуулан, 1,848.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалаас 305.7 сая төгрөгийн санхүүжилт авахаас эрүүл мэндийн төвийн байгууллагуудын эмчилгээ, үйлчилгээний гүйцэтгэлээр 222.3 сая төгрөг буюу 72.7 хувийн санхүүжилтийг авч зарцуулсан байна.

Төсөвт байгууллагын орлого 1,857.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,940.1 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 83.1 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Тайлант хугацаанд 6,163.9 сая төгрөгийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,542.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 1,378.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №5 /сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Давсан /хувиар/
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах	3,545.0	3,958.8	413.8	111.7
2	Үйл ажиллагааны орлого	368.3	621.5	253.2	168.8
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	87.0	126.5	39.5	145.4
4	Бууны албан татвар	15.9	18.3	2.4	115.2
5	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	267.9	299.1	31.2	111.7
6	Улсын тэмдэгтийн хураамж	145.0	152.0	7.0	104.8
7	Газрын төлбөр	218.8	351.7	132.9	160.8
8	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	200.0	246.2	46.2	123.1
9	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	30.4	182.8	152.4	601.5
10	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	25.0	100.7	75.7	403.0
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	19.2	20.5	1.3	106.6
12	Бусад татвар, хураамж	36.1	42.9	6.8	118.9



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

13	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	134.7	146.1	11.4	108.5
14	Хадгаламжийн хүүгийн орлого	751.9	777.3	25.4	103.4
15	Торгуулийн орлого	451.6	550.1	98.5	121.8
16	Бусад орлого	49.9	113.9	64.0	228.2
17	Хөрөнгө борлуулсны орлого	129.5	142.7	13.2	110.2
	Дүн	6,476.2	7,851.1	1,374.9	121.2

Татварын орлогын төлөвлөгөө нийт 1,374.9 сая төгрөгөөр давж биелснээс материаллаг хэмжээгээр давж биелсэн 3 нэр төрлийн орлогыг тодруулбал:

➤ *Ан амьтны нөөц ашигласны төлбөр 6 дахин давж биелсэн.*

Үүнд орлогын төлөвлөгөө батлагдаагүй Дэрэн, Гурвансайхан сумд нийт 84.1 сая төгрөг, Өлзийт, Эрдэнэдалай сумд төлөвлөгөөг 2.0-6.7 дахин давуулан биелүүлсэн нь нөлөөлжээ. Шалтгааныг тодруулахад БОАЖЯ-аас ангийн зөвшөөрлийн төлөвлөгөөг төсөв батлагдсанаас хойш ирүүлдэг, идлэг шонхор шувууг барих төлбөрийн төлөвлөгөөг батлагдаагүйтэй тус тус холбоотой байна.

➤ *Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 4 дахин давж биелсэн.*

Энэ нь тайлант онд Говь-Угтаал сумын нутагт уул уурхайн компани тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулснаас 2.3 дахин, харин Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт сумдын өмнөх оны ус ашигласны төлбөр он дамжиж орсноос орлогын төлөвлөгөө 2.4-13.2 дахин давж биелсэн.

➤ *Бусад орлого 2.3 дахин давж биелсэн.*

Энэ нь Луус сум жоншны гарал үүслийн гэрчилгээний төлбөр болон баяжмалтай шороо борлуулсны орлого орсноос 6.8 дахин, Сайнцагаан сум шүүхийн шийдвэрээс торгуулийн шийтгэлийн 40 хувийг төвлөрүүлснээс 2.8 дахин давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ дараах нэр төрлийн 3 орлогыг бууруулан баталсныг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №6 /сая төгрөг/

Татварын нэр төрөл	Нэгтгэсэн тайлангаар				Зөрүү	
	Төлөвлөгөө			Гүйцэтгэл	Баталс наас	Тодотгос ноос
	баталсан	тодотгосон	өөрчлөлт			
Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	42.0	25.0	-17.0	100.7	58.7	75.7
Улсын тэмдэгтийн хураамж	113.1	90.3	-22.8	152.0	38.9	61.7
Бусад орлого	39.0	36.1	-2.9	42.9	3.9	6.8



Дээрх 3 нэр төрлийн орлогын гүйцэтгэл анхны батлагдсан төлөвлөгөөнөөс 3.9-58.7 сая төгрөгөөр давж биелсэн байгаа нь орлогыг үндэслэлгүй, тооцоо, судалгаагүйгээр тодотгол хийж бууруулсныг харуулж байна.

Сумдын орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг харьцуулахад нийт 450.2 сая төгрөгөөр давж биелжээ.

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хүснэгт №7 /сая төгрөг/ Давсан/тасарсан	
				дүнгээр	хувиар
1	Дэлгэрцогт	20.7	25.8	5.1	24.6
2	Дэрэн	25.3	89.5	64.2	253.7
3	Говь-Угтаал	38.4	50.8	12.4	32.3
4	Цагаандэлгэр	11.3	19.9	8.6	76.1
5	Баянжаргалан	44.8	63.9	19.1	42.6
6	Өндөршил	23.7	41.3	17.6	74.3
7	Гурвансайхан	55.0	125.6	70.6	128.4
8	Өлзийт	39.7	99.2	59.5	149.9
9	Хулд	53.0	37.0	(16.0)	(30.2)
10	Луус	21.9	33.9	12.0	54.8
11	Дэлгэрхангай	24.9	29.8	4.9	19.7
12	Сайхан-Овоо	21.5	33.4	11.9	55.3
13	Эрдэнэдалай	66.2	118.7	52.5	79.3
14	Сайнцагаан	240.2	349.0	108.8	45.3
15	Адаацаг	40.4	59.4	19.0	47.0
Нийт дүн		727.0	1,177.2	450.2	161.9

Харин төлөвлөгөө, гүйцэтгэлийг сумдаар нь авч үзвэл Хулд сум 16.0 сая төгрөгөөр төлөвлөгөөг тасалж, бусад сумд 4.9-108.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хулд сумын орлогын төлөвлөгөө 16.0 сая төгрөгөөр тасарсан нь үйл ажиллагааны орлого 70.2 хувь, газрын төлбөр 16.0 хувь, хог хаягдлын үйлчилгээний хураамж 59.4 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Дээрх 3 нэр төрлийн орлого тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- *Үйл ажиллагааны орлого*: тус сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг жоншны уурхай ажиллаагүй,
- *Хог хаягдлын үйлчилгээний хураамж*: Хураамжийн хэмжээг тогтоосон ИТХ-ын тогтоол оройтож гарсан, айл өрхүүдэд нэхэмжлэх өгсөн боловч бүрэн төвлөрүүлээгүй,
- *Газрын төлбөр*: Тайлант онд орлогын төлөвлөгөө өндөр батлагдсан, сумын малчид отор нүүдлээр явсан зэргээс шалтгаалан тасарсан байна.

Аудитын илрүүлэлт

ТЕЗ-ийн харьяа төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар сумдын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг орон сууцны зориулалтаар үнэ төлбөргүйгээр ашиглуулсан, түрээсийн орлогыг дутуу тооцож төвлөрүүлсэн зэрэг төсвийн байгууллагын орлого бүрдүүлэлттэй холбоотой зөрчлүүд илэрсэн тул хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна.



Цаашид орлогыг хугацаанд нь бүрэн тооцож, төвлөрүүлэхийг бүх шатны төсөв захирагч нар анхаарч, аймгийн Орон нутгийн өмчийн газраас тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

2.1 Орон нутгийн төсвийн зарлагыг өмнөх оноос 10,375.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас ирүүлсэн ТЕЗ нарын 2020 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар, удирдамжид Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа Засгийн газраас баталсан төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж буй бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилна гэж тусгасан байна.

Энэхүү бодлого, зарчмын хүрээнд 2020 оны орон нутгийн төсвийн төслийг нийт 21,662.3 сая төгрөгөөр боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3² дахь хэсэгт заасны дагуу Сангийн яаманд хүргүүлжээ.

ТЕЗ-ийн хүргүүлсэн төсвийн төслийг Сангийн яам 21.7 хувь буюу 4,711.4 сая төгрөгөөр бууруулж, 16,950.9 сая төгрөгөөр хянасан байна.

Дундговь аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсвийн нийт зардлыг 52,775.4 сая төгрөгөөр баталжээ.

Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 3 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт тодотгол хийж, 889.2 сая төгрөгөөр бууруулан 51,886.2 сая төгрөг болгон баталжээ.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсөвт ИТХ-ын тогтоолоор 1 удаа тодотгол, 1 удаа өөрчлөлт оруулсан байна.

Орон нутгийн төсвийг баталсан, тодотгол хийж, өөрчлөлт оруулсан тогтоолуудыг хүснэгтээр харууллаа.


² Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3² дахь хэсэг /Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх/



Хүснэгт №8 /сая төгрөг/

Зарцуулах эрх	ИТХ-ын тогтоол			Зөрүү
	2019.12.04 №12	2020.09.16 №03	2020.12.05 №10	
ОНТБ	11,420.2	11,202.2	11,232.6	(187.6)
ОНХС	2,365.3	2,170.8	2,170.8	(194.5)
Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	9,783.1	9,584.2	9,553.8	(229.3)
ТЗШБ	29,206.8	28,929.0	28,929.0	(277.7)
Нийт дүн	52,775.3	51,886.2	51,886.2	(889.2)

УИХ ковид 19 цар тахлын нөлөөгөөр үүссэн эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж ОНХС-ийн орлогын шилжүүлэг, ТЗШБ-уудын санхүүжилт, орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулж баталсантай холбоотойгоор орон нутгийн төсвийг 889.2 сая төгрөгөөр бууруулжээ.



Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 10 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн байгууллагуудад 11,232.6 сая төгрөг, ОНХС-д 2,170.8 сая төгрөг, сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 9,553.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 28,929.0 сая төгрөгийг зарцуулахаар тус тус баталсан байна. Зардлын төлөвлөгөөг өмнөх онтой


харьцуулахад 9,949.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсны дийлэнх хувийг ОНТБ, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн өсөлт эзэлж байна.

Хүснэгт №9 /сая төгрөг/

Зарцуулах эрх	2019	2020	Зөрүү
ОНТБ	6,423.3	11,232.6	4,809.3
ОНХС	3,822.4	2,170.8	(1,651.6)
Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	4,694.8	9,553.8	4,859.0
ТЗШБ	26,995.8	28,929.0	1,933.2
Нийт дүн	41,936.3	51,886.2	9,949.9

Аймаг, сумдын ИТХ-аар орон нутгийн төсвийн нийт зардлын төлөвлөгөөг 58,127.8 сая төгрөгөөр баталжээ.

Орон нутгийн төсвийн нийт зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг сүүлийн 4 жилээр харьцуулан графикаар харууллаа.



Графикаас харахад төсвийн нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл 2017 оноос 2019 оны хооронд жигд өсөлттэй байсан боловч 2020 онд өмнөх оноос төлөвлөгөө 10,375.2 сая төгрөг, гүйцэтгэл 5,389.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөөг 10,375.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь ТЕЗ нарын 2020 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар, удирдамжийн³ дагуу 2020 оны төсвийн тухай хуулиар санхүүгийн дэмжлэгийг өмнөх оноос 2,327.0 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 1,549.1 сая төгрөг, ТЗШБ-ын санхүүжилтийг 5,651.2 сая төгрөгөөр тус тус өсгөн баталсантай холбоотой байна.

Тайлант онд төсвийн нийт зарлагыг дараах зардлуудад зарцуулахаар төлөвлөжээ. Үүнд:

- Бараа, ажил үйлчилгээний зардалд 47,484.9 сая төгрөг;
- Татаас, урсгал шилжүүлэгт 1,257.8 сая төгрөг;
- Хөрөнгийн зардалд 6,981.3 сая төгрөг;
- Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 2,403.8 сая төгрөг.

Төсвийн нийт зардлын төлөвлөгөөг зардлын бүлгээр өмнөх онтой харьцуулан графикаар харууллаа.



³ /Орон нутгийн төсөвт тулгамдаж байгаа төсвийн тэгш бус хуваарилалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2019 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн онцлог, хэрэгцээнд тохирсон байдлаар төсвийн татаас, шилжүүлгийг хуваарилах/

Графикаас харахад өмнөх оноос бараа, ажил үйлчилгээний зардал 7,855.0 сая төгрөг, татаас ба урсгал шилжүүлэг 406.9 сая төгрөг, хөрөнгийн зардал 2,385.1 сая төгрөгөөр тус тус өссөн байхад эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 271.8 сая төгрөгөөр буурсан байна.

2.2 Төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил өмнөх оноос 19.0 хувиар буурсан ч төсвийн хөрөнгийг үрэлгэн, хууль, тогтоомж зөрчин зарцуулсан зөрчлүүд илэрсээр байна.

Тус онд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 58,127.8 сая төгрөгөөр төлөвлөж, 49,631.5 сая төгрөг буюу 85.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №9 /сая төгрөг/

Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
ОНТБ	24,022.2	17,662.2	6,360.1	73.5
ТЗШБ	28,929.0	26,996.8	1,932.2	93.3
ОНХС	5,176.6	4,972.6	204.0	96.1
Нийт дүн	58,127.8	49,631.5	8,496.3	85.4

Гүйцэтгэл дутуу байгаа шалтгаануудыг тодруулахад:



ОНТБ-ууд 73.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийн олголт, төсөл сангийн зарцуулалт, хөрөнгийн зардлын гүйцэтгэлээс;



ТЗШБ-ууд 93.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эрүүл мэндийн даатгалаас санхүүжих 83.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, улсын төсөвт 1,848.9 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй;



ОНХС 96.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь улсын төсвийн санхүүжилтээс 204.0 сая төгрөгийг дутуу авсан мөн батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт ирээгүй, жилийн эцэст ирснээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүд хийгдээгүйтэй тус тус холбоотой байна.


Тус онд “Ковид-19” цар тахлаас шалтгаалан бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор Сургууль, цэцэрлэгийн зардлын хэмнэлт дансанд 1,802.5 сая төгрөгийг шилжүүлэн, улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Үүнээс орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 918.2 сая төгрөгийг төвлөрүүлэг шилжүүлгээр, 884.3 сая төгрөгийг зардлаар тайлагнасан байна.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 98⁴ болон 114⁵ дүгээр тогтоолуудын дагуу зарцуулагдсан 884.3 сая төгрөгийг зардлаар тайлагнах тухай чиглэл, зааврыг Сангийн яамнаас ирүүлсэнтэй холбоотойгоор төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлаар тайлагнажээ.

ОНХС 96.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь 2020 оны төсвийн тухай хуульд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт 5,176.6 мянган төгрөгийг олгохоор баталсан боловч 204.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Төсвийн нийт гүйцэтгэлийг 85.4 хувьтай тайлагнасан нь улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн 2,570.8 сая төгрөг, улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан санхүүжилт 287.4 сая төгрөг, ИТХ-ын тогтоолоор эх үүсвэрээр батлаагүй төсөвт байгууллагуудын эхний үлдэгдлийн 227.5 сая төгрөг, Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд 5,839.3 сая төгрөгийг тайлагнасантай тус тус холбоотой байна. Үүнийг диаграммаар харуулбал:



Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг бүлгийн дүнгээр харуулбал:

Хүснэгт №10 /сая төгрөг/


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бараа, ажил үйлчилгээний зардал	47,484.9	44,192.6	3,292.2	93.1
Татаас ба урсгал шилжүүлэг	1,257.8	1,236.4	21.4	98.3
Хөрөнгийн зардал	6,981.3	2,884.1	4,097.2	41.3
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,403.8	1,318.4	1,085.4	54.8
Нийт дүн	58,127.8	49,631.5	8,496.3	85.4

Хүснэгтээс харахад хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийн гүйцэтгэл бага байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоол “Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай”

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

- Хөрөнгийн зардал 41.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь ОНХС-ийн санхүүжилт хуваарийн дагуу ирээгүй, жилийн эцэст ирснээс хөрөнгө оруулалтын ажлын тендерүүд оройтож зарлагдсан;
- Монгол Улсын Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 114 дүгээр тогтоолоор хөрөнгийн зардлыг түр зогсоож, хойшлуулсан;
- Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 54.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь сум хөгжүүлэх сангаас өмнөх онуудад олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, шаардлага хангасан төсөл цөөн батлагдсантай холбоотой байна.



Нийт зардлын 89.0 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 2.5 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, 5.8 хувийг хөрөнгийн зардал, 2.6 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл тус тус эзэлж байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т */Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах/* заасны дагуу Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 2 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийг 44,242.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №11 /сая төгрөг/

Үзүүлэлт	Гүйцэтгэл		Өсөлт/бууралт
	2019	2020	
Бараа, ажил үйлчилгээний зардал	38,525.0	44,192.6	5,667.6
Татаас ба урсгал шилжүүлэг	847.6	1,236.4	388.8
Хөрөнгийн зардал	3,151.6	2,884.1	(267.5)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	1,718.2	1,318.4	(399.8)
Нийт дүн	44,242.4	49,631.5	5,389.1

Өмнөх онтой харьцуулахад төсвийн гүйцэтгэл 5,389.1 сая төгрөгөөр өссөн боловч зардлын нэр төрлөөр авч үзвэл хөрөнгийн зардал 267.5 сая төгрөг, Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 399.8 сая төгрөгөөр тус тус буурсан байна.


Нийт төсвийн гүйцэтгэлийн 89.0 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, бараа, ажил үйлчилгээний зардлын 69.9 хувь буюу 30,906.5 сая төгрөгийг ажиллагсадтай холбогдсон зардал эзэлж байна. Ажиллагсадтай холбогдсон

зардал өмнөх оноос 4,209.5 сая төгрөгөөр өссөн нь 2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг төрийн үйлчилгээний албан хаагчдад үндсэн цалингийн 5-25 хувиар тооцож олгодог болсонтой холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

ТЕЗ-ийн харьяа төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой нийт 411.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнээс 25.1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 362.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, үйл ажиллагааг сайжруулахаар 23.7 сая төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлжээ.

Төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь ангилан диаграммаар харууллаа.



Нийт зөрчлийн 48.0 хувийг хууль тогтоомж зөрчсөн, 31.0 хувийг төсвийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, 11.0 хувийг батлагдсан эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан, 5.0 хувийг батлагдаагүй орон тоонд ажилласан албан хаагчдад цалин, ажил хавсарсны нэмэгдэл олгосон, 5.0 хувийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж,

хөрөнгө зарцуулсан зөрчил тус тус эзэлж байна.

Зардлын данстай холбоотой илэрсэн нийт зөрчил өмнөх оноос 96.4 сая төгрөгөөр буурсан сайн үзүүлэлттэй байна. Гэвч төсөв захирагч нарын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгээс харахад төсвийн хөрөнгийг үрэлгэн, хууль, тогтоомж зөрчин зарцуулсан зөрчлүүд илэрсээр байгаа нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Үүнд:

- Засаг дарга болон Засаг даргын Тамгын газраас гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйлс, хүндэтгэлийн зоог барихдаа батлагдсан хэмжээг хэтрүүлэн 25.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын

норматив"-ын 2⁶-т заасныг зөрчсөн байна. Дээрх норматив нь 21 жилийн өмнө батлагдсан, бараа, ажил үйлчилгээ үнэ хөлс нэмэгдсэн зэрэг нь уг тогтоолыг баримтлан ажиллахад хүндрэл үүсгэж, зөрчил давтагдан гарсан;


- Эдийн засгийн ангилал зөрчин хөрөнгө зарцуулсан зөрчил нийт зөрчлийн 11 хувийг эзэлж байгаа нь төсвийн шууд захирагч нарын төсвийн төслийг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөж, батлахгүй байгаагаас шалтгаалж байна. Энэ нь зөрчил давтан гаргахад хүргэж байна.
- Төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, зах зээлийн үнээс өндрөөр хөрөнгө бэлтгэсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус, хуурамч баримтаар гүйлгээ хийж хөрөнгө зарцуулсан зөрчил нийт зөрчлийн 36 хувийг эзэлж байгаа нь дотоод хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалж байна. Энэ нь урсгал зардлыг нэмэгдүүлэх, төсвийн зарцуулалтын үр ашгийг бууруулж байна;
- Батлагдаагүй ажлын байранд цалин хөлс, нэмэгдэл олгосон зөрчил нийт зөрчлийн 5 хувийг эзэлж байгаа нь мөрдөгдөж байгаа орон тоо нь тухай байгууллагын ажлын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцээгүй, ТЕЗ өөрийн харьяа байгууллагуудын орон тоог батлаагүйтэй тус тус холбоотой байна. Энэ нь хууль тогтоомж зөрчигдөх сөрөг нөлөөтэй байна.

Дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дээд шатны байгууллагад 1 санал, аймгийн Засаг даргад 3 зөвлөмжийг тус тус хүргүүлжээ.

2.3 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.

ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 4,004.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,644.5 сая төгрөгийг зарцуулан, 360.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Нэмэлт төсвийн эх үүсвэр

Нэмэлт төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг диаграммаар харуулбал нийт орлогын 91.0 хувийг

⁶ Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд хийх хүлээн авалтын нэг хүнд ногдох зардал нь 10 хүртэл хүн оролцоход 12000 төгрөг, 50 хүртэл хүн оролцоход 10000 төгрөг, 50-иас дээш хүн оролцоход 8000 төгрөгөөс тус тус илүүгүй байна/



дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 7.2 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 1.7 хувийг орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого тус тус эзэлж байна.

Тус онд төсвийн ерөнхийлөн захирагч 69.7 сая төгрөгийн хандив, тусламжийг авч бүртгэл тайланд тусгажээ. Үүнийг байгууллагуудаар харуулбал:

- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар 56.9 сая төгрөг,
- Соёлын байгууллагууд 7.0 сая төгрөг,
- Боловсролын байгууллагууд 3.5 сая төгрөг,
- Эрүүл мэндийн байгууллагууд 2.3 сая төгрөгийн хандив, тусламжийг тус тус авсан байна.

Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу төлөвлөгөөнөөс давсан орлого 172.6 сая төгрөг, төсвийн жилийн дундуур шинээр бий болсон орлого 47.1 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 70.1 сая төгрөг, нийт 289.8 сая төгрөгийг эрх нээлгэн зарцуулжээ.

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,645.4 сая төгрөг төвлөрүүлснийг эх үүсвэрээр нь харууллаа. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлаас 1,681.0 сая төгрөг,
- Яамдаас 80.1 сая төгрөг,
- Төсөвт байгууллагуудаас 1,814.5 сая төгрөг,
- Төсөл хөтөлбөрөөс 69.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн эх үүсвэр өмнөх оноос 775.9 сая төгрөгөөр өссөн боловч 2 нэр төрлийн орлого, тусламж буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12 /сая төгрөг/

№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	2019 он	2020	Өсөлт/ Бууралт
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	190.9	69.7	(121.2)
2	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,284.5	3,645.4	2,360.9
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	470.6	289.8	(180.8)
Дүн		1,946.0	4,004.9	775.9


Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өмнөх оноос 2,360.9 төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлаас хэлмэгдүүлэлтийн цагаатгалд олгосон нөхөн олговорт 1,681.0 сая төгрөгийг хуваарилсан;

- Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үүднээс Дундговь аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/338 дугаар захирамжаар төсөв захирагч нарын төсвөөс батлагдсан төсвийн 1 хувьд багтаан хөрөнгө гаргах зөвшөөрөл олгосны дагуу улсын төсвийн байгууллагуудаас 15.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудаас 133.6 сая төгрөг, нийт 148.6 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй тус тус холбоотой байна.

Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 121.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд “Гурван мянган уртын дууч, морин хуурчдын урлагийн их наадам”-ыг зохион байгуулж, хөрөнгийн эх үүсвэрийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас авсан хандиваар санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсвийн зарцуулалт



Нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн зардалд 3,644.5 сая төгрөгийг тайлагнаснаас бараа, ажил үйлчилгээний зардалд 2,726.3 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 38.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 879.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнийг диаграммаар харууллаа.

Бараа, ажил үйлчилгээний зардал нийт зардлын 74.8 хувийг эзэлж байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын зарцуулалттай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад өмнөх оноос 1,773.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №13 /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2019	2020	Өсөлт/ бууралт
1	Бараа, ажил үйлчилгээний зардал	1,836.6	2,726.3	889.70
2	Татаас, урсгал шилжүүлэг	29.10	38.6	9.54
3	Хөрөнгийн зардал	5.40	879.6	874.19
Нийт дүн		1,871.1	3,644.5	1,773.4

Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлт нь шүүхийн шийдвэрийн дагуу олгосон хэлмэгдүүлэлтийн цагаатгалд олгосон нөхөн олговор, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зардлаас шалтгаалсан байна.

Харин хөрөнгийн зардал Нэгдсэн Үндэсний байгууллагаас хэрэгжүүлж буй “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслөөс 641.8 сая төгрөгийн хөрөнгийн зардлын санхүүжилттэй холбоотойгоор өссөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орлогыг судалгаа, шинжилгээ хийлгүй, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан бодитой бус төлөвлөж байна.
2. Орон нутгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.
3. Орон нутгийн төсвийн зарлагыг өмнөх оноос 10,375.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
4. Төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил өмнөх оноос 19.0 хувиар буурсан ч төсвийн хөрөнгийг үрэлгэн, хууль, тогтоомж зөрчин зарцуулсан зөрчлүүд илэрсээр байна.
5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

- ✚ Орлогыг төлөвлөхдөө тухайн тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх онд орсон нэг удаагийн шинж чанартай орлого зэргийг тооцон, орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;
- ✚ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т */өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/* заасны дагуу төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, худалдан авах ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хянах тогтолцоог бий болгох;
- ✚ Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8-д */Тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах/* заасны дагуу төсвийн байгууллагын орон тоог жишиг норм, стандартыг баримтлан төсвийн захирагч бүрээр хүний нөөцийн судалгаа, ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн баталж, мөрдүүлэн хяналт тавих;

- ✚ Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 */Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана/, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу төсөв захирагч нарын төсвийн төслийг тооцоо, судалгаанд үндэслэн, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөх;*

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын норматив" нь 21 жилийн өмнө батлагдсан, тухайн үеэс бараа, ажил үйлчилгээ үнэ хөлс нэмэгдсэн зэргээс шалтгаалан уг тогтоолыг мөрдөж ажиллахад хүндрэл үүсэж, зөрчил давтагдан гарсаар байна. Иймд "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын нормативыг цаг үе, эдийн засгийн нөхцөл байдал, бараа, ажил үйлчилгээний үнийн өөрчлөлт зэрэгт нийцүүлэн тогтоох" гэсэн зөвлөмжийг хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газарт уламжилж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Б.ГАНТУЯА

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

Т.БАТСАЙХАН



НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,127,811.7	49,631,542.1
УРСГАЛ ЗАРДАЛ	48,742,718.9	45,429,036.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,484,882.5	44,192,645.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,021,683.4	27,465,120.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,631,113.3	3,441,410.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,456,546.2	4,280,679.4
Хангамж, бараа материалын зардал	1,388,949.0	1,349,332.4
Нормативт зардал	2,953,731.4	1,894,192.6
Эд хогшил, урсгал засварын зардал	2,386,313.8	2,048,310.4
Томилолт, зочны зардал	303,474.9	259,159.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,730,359.4	1,620,841.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,612,711.1	1,833,598.7
ТАТААС	427,962.8	427,962.8
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	96,300.0	96,300.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	96,300.0	96,300.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	331,662.8	331,662.8
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	331,662.8	331,662.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	829,873.6	808,428.4
Бусад урсгал шилжүүлэг	829,873.6	808,428.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,981,297.9	2,884,068.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,403,794.9	1,318,437.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,127,811.7	51,815,522.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,799,883.8	31,747,028.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,737,340.1	17,905,971.3
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	305,719.0	222,337.1
ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,284,868.8	1,940,185.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	3,655,294.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,839,275.1



НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,004,888.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,125,302.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,726,256.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,330.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,439.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,873.3
Хангамж, бараа материалын зардал	190,361.0
Нормативт зардал	25,723.7
Эд хогшил, урсгал засварын зардал	127,025.6
Томилолт, зочны зардал	9,891.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,058,717.2
Бараа үйлчилгээний бусад зардал	249,894.3
ТАТААС	175.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	175.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,870.5
Бусад урсгал шилжүүлэг	38,463.3
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	360,407.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	879,586.7
Дотоод эх үүсвэрээр	879,586.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,004,889.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	4,004,889.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.4



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум

Утас/факс: 70592895

И-мэйл: info@dundgovi.gov.mn

2021.04.20 № 1/598

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд санал тайлбар байхгүй. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн менежментийн захидлаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор хэрэгжүүлж, хэрэгжилтийг хүргүүлнэ.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



Т.Батсайхан
Т.Оюун-сүрэнцэрт
Тайланг оруулж,
ауригын тайланг
баталгаажуулах
 20/20

485210001



АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/07


Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн аудитын тайлан /ДУА-2021/01- СТА-ТЕЗ/-г баталсугай.
2. “Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг санхүүгийн аудитын албаны ахлах аудитор /Т.Батсайхан/, аудитор /Т.Оюун-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.НАРАНЦАЦРАЛ

0012010022



